

**“BA ~ MA- SI-, QA~ GA- SI-, SI- BA- ~ MA-, SI- QA ~ GA” ГЭСЭН
ХОРШМОЛ ҮЕ-УТГАЛБАРААС ҮҮССЭН ҮГСИЙН ТУХАЙ**

М.Базаррагчаа¹

Б.Я. Владимирцов монгол үгийн тэргүүн үеийн эгшиг нь өөр хоорондоо сэлгэж, үгийн хувилбар болох бие даасан үг бүтээж болох тухайд *basir ~ bisir* (лукавство, обман), *basil- ~ bisil-* (заниматься, предаваться чему, прилежать), *bisil-, ~ bašit- > bisil-, basil-* (заниматься, прилежать), *bisiγün > bisiyün* (смышленный, проворный) *tur., man. baš* (толгой)², *tel. üiš* (довариваться, варить делаться мягким) *bučal-* (кипеть) (стр. 174) гэсэн бол

Б. Ринчен “бяслаг” хэмээх үг нь “*busilay, basilay, bisilay*” гэсэн хувилбартайгаас гадна Баяд, дөрвөд аялгуунаа “*bašlak*” гэнэ³ гээд, бяслаг, башлаг, бушлаг” гэдгийн бис-, бас-, буш-“ гэдэг язгуурын утга нь төрөл төс түрэг хэлнээс тодрон гарах язгуур үг байнам” гэжээ. Энэ нь монгол хэлний *basiγi-* (башийх) гэсэн дүрслэх үгээс үүсэлтэй. “*ba-si-*” (баших- овоорох, бөөгнөрөх, шавалдах) гэсэн эс тусах үйл үгээс эхтэй байна.

Б. Ринчен “Түрэг хэлтэнд *bis-* язгуур үгийн *bus-* гэсэн хэлбэр нь “чанах болгох” гэсэн утгатайгаар якуд хэлнээ буйгаас манай бислаг, бушлаг гэдэг маань “чанах, буцалган болгох” гэсэн утгатай үгнээс үүсэн, чанамал гэсэн ухаантай үг болох нь садан хэлнээс учир утга нь олддог байна⁴ гэснийг үзвэл, “*basi-*” (баших), “*siba-*” (шавах) хэмээх монгол үгээс үүсэлтэй гэж тайлсангүй, харин Б.Я. Владимирцов энэ үгийг *bučal-* (буцлах) хэмээх үгтэй холбосон нь “*si-*” үе- утгалбар нь “*ča...*” үе- утгалбартай сэлгэсэн болохыг тогтоожээ. *basi-* (баших- ээдэх, исэх, бөсөх, бүсэх) хэмээх үг нь “башилдаж, шавалдах” гэсэн утгаас үүдэлтэй “*bašim* (цухал, явцуу), *bašiyū* (бачуу, давчуу) үгтэй “*si-či-*”-гийн сэлгэцээр үүссэн ба “*baši* (бааш, бач) ~ *basir* (башир хашир), *büči-* (бүчих, бүтээх хучих) ~ *quči-* (хучих, битүүлэх) хэмээх үг салаалжээ.

“*basi-*”, “*qasi-*” хоёр нь “*ba~qa-*”-гийн сэлгэцээр утга ялгарсан ба эдгээр нь “овоорох, бөөгнөрөх, шахалдах” гэсэн утгатай юм. “*qasi-*” гэдгийн “*a*” нь “*o*”-той сэлгэвэл, “нийлсэн, холилдох” гэсэн утгатай ч түүнээс “уг юм нягтрах”, улмаар “уг дүрс биет” нь эв хавгүй холилдсоноос хүний далд шооч инээд хүрдгээс “*qošung, qosing*” (хошин) хэмээх үг бүтжээ. Энэхүү авиа сэлгэх, утга салаалахаас “*qosi*” (хошоо ажил), *qos. tur. qoš; qosi qoγuā* (хош хороо), *qosi-* (хоших, хорших)⁵ хэмээх үг үүссэн ба Г.И. Рамстедт “*quši*” (хуш мод) –гэдгийн “*u*” нь “*o*”-той сэлгэнэ гэж үзжээ.

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Б.Я. Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика, Лгр., 1929, стр. 145

³ Б. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй, Дэд дэвтэр, Авианзүй, Уб., 1966, 127-р т.

⁴ Б. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Хэлбэр судлал, Гутгаар дэвтэр, Уб., 1966, 55-р т.

⁵ G.J. Ramstedt. Kalmückisches wörterbuch. Helsinki, 1935, p. 189-190

Монгол хэлний “qa- si-” (хаах) гэсэн хоршмол үе-утгалбар нь байр сэлгэн тонгорч, si- qa (хавчих) гэсэн хоршмол үе-утгалбар бүхий үг бүтжээ.

- 1) Эхний үгийн тэргүүн үе-утгалбарын эгшиг нь “o, u, e, ö” эгшгээр сэлгэн, qo-si, qo-si-mu-γ (эмжээртэй юмны зах хөвөөний дотуур даруулж оёсон эмжээр), qo-si (холбох), qo-si-la-ng (зөв буруугаар томсон дээс), qo-si –yā (хэдэн зүйлийн өнгө хослуулан хийсэн эрээн тууз), qo-šu –i (хос давхар), qo-šo-ng (шог инээдэмтэй үг яриа), “qo-šu-ng” хэмээх үгийн талаар С. Дулам “Харин бидний бодлоор, орчин цагийн “qo-šu-ng” хэмээх үг нь šoy, šoylal гэсэн утгатайг бодвол дундат эртний монгол хэлний “qošaγ, qošuγ” гэдэг үг нь хошин шүлгийг хэлдэг байсан байж магадгүй”⁶ гэж үзсэн нь үнэний хувьтай юм. Үүнд, “qo-ši-ng” гэдгийн тэргүүн ба дэд үе-утгалбар байр сэлгэн тонгорч, “si-qu-, si-qū-yi-” (шухайх), улмаар “qu” нь “γu”-тай сэлгэж, “si-qū ” (шуу, гарын шуу, шуу гүйх) болж, эхний “i” нь “u, o” болж, “γu” үе-утгалбар эгшгээ гэж, үе-утгалбар задарч, “šo-γ” (шог) хэмээх үг бүтсэн тул “qošong” хэмээх үгтэй амь нэгтэй ажээ. Энэ үгийн “-γ” нь “r”-тэй сэлгэвэл “šo-ru” (юм хумыг хатгах сүлбэхэд хэрэглэх зүйл)⁷ хэмээх үг бүтэж, “šo-r-bu-γ” (гашуун, амтлах эрхтнийг шорлох мэт хатгах), šo-r-bū-yi (үс өд мэт юмсын сөдийх), so-r-bi-yī, šō-r-bū-yī-, ša-r-bi-yī-, si-r-bā-yi-“ зэрэг үгсээс эхтэй болно.
- 2) qu-si-γa (мод ба жимсний бөмбөгөр, ясархаг цөмөө, эрийн өндөг), qu-si (мөнх ногоон мод, үрээр нь тос шахаж болно), qu-si-γū (юмны шувтайж барагдсан үзүүр, этгээд)
- 3) qa-ša-ng (удаан, залхуу, хуучирсан эдлэл, удсан тос), qa-si-r (туршлагатай догь), qa-si-ra- (туршлагатай болох, залхах), qa-s\ i (эрдэнийн бөх бат чулуу)
- 4) ke-si-g (өглөг ашиг)
- 5) kō-si- (гөнжих, хөндөлдөн хаах), kō-si-yē (дурсгалын зүйл), kō-si-gū-n (хойрго, зөрүүд), kō-si-ge (хаах, далдлах юм) зэрэг үгс үүсжээ.

Эдгээрийн “qa...” үе-утгалбар нь “тал тал тийшээ томрох”, “si...” үе-утгалбар нь “нарийн ширийн, нягтрах” гэсэн утгатай тул дээрх үгс нь “нягтарч бөөгнөрөх” гэсэн ерөнхий утгатайгаас гадна, “a”-т үгс нь “томорсоор уг зүйлийг халхлах, “o”-т үгс “чигжлэн нягтлах, холбох нийлүүлэх, “и”-т үгс нь “бөөгнөрснөөс нэг тийш хандах (qu-si-γū) О. Ковалевский “qosiγū” (хошуу) гэж “o”-гоор ялгажээ⁸ “e”-т үгс нь “бөөн олз ашиг”, “ö”-т үгс нь “хөндөлдөн тээр болох” гэсэн дор дорын салаалсан өвөрмөц утгатай болно. Гэтэл үе-утгалбар тонгоруулбал

- 1) si-qa- (нягт чигжих, тулган шаардах) si-qa-γu-d (төрөх ойртсон нь)
- 2) ša-qu-γū-ra- (юманд дурлах сонирхох), šoquγūqa- (ихэд хүсэн дурлах)
- 3) šu-qū-yi- (нарийсах, явцуурах)
- 4) si-kū-r (нар борооноос халхлах хэрэгсэл) зэрэг үгс үүссэн нь “бөөгнөрснөөс нягтрах” гэсэн утгатай болсон ба “нэг юманд чиглэх, нарийсах утга салаалсан ба гагцхүү “sikūr” (шүхэр) нь kōsige (хөшиг) гэдэг шиг “хаах, халхлах” утгатай ажээ.

Дээрх “qa...” үе-утгалбар нь “бөөгнөрч багшрах” гэсэн утга бүхий “ba...” үе-утгалбартай сэлгэвэл:

⁶ С. Дулам. “Монгол тооны бэлгэдэл”, МУҮИС., МС-ын хүрээлэн, ЭШБ., №6 (114), Уб., 1995, 86-р т.

⁷ Я. Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь, Уб., 1966, 854-р т.

⁸ О. Ковалевский. Монгольско-русско-французский словарь, I, II, Казань, 1846, стр. 905

- 1) ba-si- (ээдэж бөөгнөрөх, овоорох), ba-si- r (хашир), ba-si-ldu-(овоорох), ba-si-yi-(овоорох, бөөгнөрөх)
- 2) bo-ši-ya (хөндлөн саад, алба хөөн нийлүүлэгч, том зурмыг бошго зурам гэнэ) bo-si-γ (иш үндэс, зарлиг, зөвшөөрөл, хайр ивээл, хувь заяа) ~ bo-šu-γ, bo-šu-ya (үүдний хөндлөн мод), (bosiγ (иш үндэс) нь ši/ obuγi- (шовойх)-оос үүсэлтэй)
- 3) bu-si-γū (хурдан түргэн, шахуу давчуу) ~ bi-si-γū (бушуу), ba-si-γū (бушуу) (Эдгээр үгийн тэргүүн үеийн “a, u, i” эгшиг сэлгэсэн боловч түүний хирээр утга салаалсангүй, нэг үгийн нэрлэвэр (номема)-ийн хувилбар болсон байна) зэрэг үг бүтжээ. Харин эдгээрийн тэргүүн ба дэд үе-утгалбар сэлгэвэл
- 1) si-ba-γū-n (шувуу- цугламтгай, нисдэг сүрэг), ša-bi (бяцхан халбага), si-ba-Ḥi (цугламтгай, бөөнөөр амьдрагч), si-ba- (бөөгнөрөх), si-ba-r (нойтон нялцгай шороо), si-ba-γā (буур шавах), si-ba-γ (бутлаг ургамал, cf. ba-si-γ (хатуу жимстэй өвслөг ургамал), si-ba-da- (шаардах шахах), šā-bā-i (бушуу, шаламгай), ša-bā-i (гэдсэнд цус цутгасан нь)
- 2) šo-bū-yi- (үзүүр нь нарийсах), šo-bu (шов толгой), šo-bu-ng (шовойсон байдал), šo-bi-r (шовор шовор гүйх) cf. ši/ o-b-qu (шовх)
- 3) si-be- (хатгах цоолох), si-be-gē- (хялганы хурц үзүүртэй үр, Шивээ улс), si-be-gē-sū (шивсэн ором мөр), si-be-r, si-bi-r (ой модны нягт ургасан нь), si-bū-ge (нарийн үзүүртэй цоолох багаж), si-be-re- (шивэр авир орох бороо), si-be-r (шивэр авир чимээ), si-be-r-de-sū (сэнсэн борооны өчүүхэн дусал), si-be-ne-, si-be-ge-ne- (нам сэм дуугаар ярилцах), si-be-l-de- (шивгэнэх), si-be-ri- (гавшгайлах, бойжих, хүүхдийн нус шүлс нь гоожихоо болих), si-be-ri-le- (гавшгайлах, идэвхийлэх)
- 4) šō-bū-yi- (юманд нарийн үзүүр бий болох) зэрэг үгс бүтсэн нь тухайн юманд шигж орох, өөр хоорондоо бөөгнөрөх” гэсэн ерөнхий утгатай бөгөөд энэ нь “i(i)” эгшгийн “уйтан зайгаар хий нарийсан урсах үйлдлээс үүдэлтэй “нэвчих нэвтрэх” утгатай хамаатай юм. “i” эгшгийн өмнө орсон “s” нь “i”-гийн нөлөөгөөр “š” болон зөөлөрч, улмаар уг “i” эгшиг нь арын эгшигтэй ухран ижилсэж, “a, o, ō, u” болжээ.

“qa-si-“ хэмээх үгийн “qa...” үе-утгалбар нь “ya...”-тай сэлгэж, ya-si-l- (идээ ундаа язарч, бөөгнөрөн муудах), ya-si-γū-n (исгэлэн), ya-si-γū (ээдэж муудсан нь), γo-šu-γū-n (гошуун-саримс гаа зэрэг зургаан амтын нэг), ya-si-γā-l, ya-si-γā-l, ya-si-ya-n (гашуун зовлон) зэрэг үгс салаалсан нь “олон удаа чанаж хэрэглэсэн хашин” (qašang), “шог санаа хурсан хошин” (qošung) зэрэг үгийн утгатай ижил бөгөөд “qo-si\u-n-g” (хошин) гэдгийн “si\u” нь šo-γ (шог), šo-ru (шор) гэдгийн “šo” мөн бөгөөд “qo” нь 1. “γ”-тэй сэлгэсэн юм. Ингэж “qošung šoγ” гэсэн хоёр үг гарал нэгтэй болно. 2. γo-si-γū- (гошийх-юмын доторх нь “өсөж” таргалснаас бий болох дүр байдал), 3. γu-si-γū- (гушийх-уртавтар юмын тэлж томрох нь) cf. γušuγūn (гушуун), 4. ge-si-gū (ū) (ургамлын салаа мөчир), ge-si-gū-n (юмын салаа бүрэлдэхүүн, нэгж), 5. gi-si- gū-ne (шимэлдгийн язгуурын олон наст өвслөг ургамал, бажууна ч гэдэг) зэрэг үгс бий болгожээ. Эдгээр нь “бөөгнөрөх, ялгарч гадагшлах” гэсэн утгатай ба “ya...” үе-утгалбар нь “ялгарах, онцгойрох”, “si” үе-утгалбар нь “шигэх, нягтрах” гэсэн утгатай тул “ya...”-гаар эхэлсэн үгс нь “гадагшлан ялгарах” (бүхлийн хэсэг) гэсэн утгатай болох ажээ.

“si-ba-” гэдгийн “ba-” үе-утгалбар нь “ya...” үе-утгалбартай сэлгэвэл 1. si-γā- (шигтгэн оруулах), si-γā-ru-n, si-γā-ru-, si-(γā)-ru- γ (шаарч үлдсэн нь), si\a-γā-n-ša-γ, ša-γā-n-ta-γ (шааж оруулах, шанаа хавтас), si-γū- (нэг талаас нөгөө талд нь овоолох, дээл

шуух, мах нь шуугдах, утас шуух) si-γū-maγ (šū-ū-ma-γ) (өмдний шуугдах хэсэг), šū-da-γ (si-γū-da-γ) (бөхийн доод биеийн өмсгөл), si-γū-i (нягт ургасан ой бургас), si-γū-d (эгц шулуун, шуудах), si-γū-d- (шуудах, шулуудах), si-γū-dā-i (юмын шуудхан шиг хийчих сав уут) cf. ke-ū-de-i (хүүдий) (Сүүлчийн хоёр үгийг хятад гаралтай гэх нь бий)⁹ si-γū-r- (ширүүн “шууд” салхилах, мах мараа багасах, гал түймрийн эрч буурах), si-γū-r-γa (хүчтэй салхи) si-γū-r- qā-i (хөнгөн түргэн) зэрэг үгс үүсжээ. Эдгээрт орсон “γa~γu” үе-утгалбар нь “уртсаж нарийсах” гэсэн утгатай тул “шулуун, шулуудах” утга бүхий дээрх үгсийг бүтээжээ. Эдгээрт “шулуухан хүргэх мэдээчийг “si-ū-da-n” гэсэн үг хамаарна. si-γā (шаах), si-ge- (шигэх) зэргийн эхний үе-утгалбар болох “si” нь “sa” үе-утгалбараар сэлгэж, saγū- (суух-бөгсөөр юманд тулж байх, эр эм бололцон айл гэр болох) хэмээх үг салаалах ба “буур суух” ч гэж хэлэлцэнэ.

2. šo-ū (шоо- шоглох, шорлох нь), šo-ū-la- (шоглон шорлох), šo-ū-da- (гадуурхан шорлох), so-ū-r (шоор- шогч халдамхай зан), šo-γu-d (элэг доог), šō (šo-γū) (шоо дөрвөлжин, нэг цэгээс гарсан шулуунаас бүтсэн дөрвөн тэгш өнцөгт дүрс буюу юм)

3. šu-ū (хүний гарын тохойноос сарвуу хүртэлх хэсэг), šu-ū (битүү хавдар, шуу гүйх)

4. sī-da-m (шийдэм, шаадам) si-(γā)-da-m (барих тал нь нарийн, занчих тал нь бүдүүн зэвсэг)

5. si-ge-, si-gi-, si-gi-d- (шигэх, шигдэх- шаан оруулах) si-gi-d(ū)-sū-n (шүдний шиг мах) si-gi- (шүдний завсарх мах, өчүүхэн бага), si-gi-ne-g (шигнэг- үзүүр бүхий шор, тэвнэ), si-gi-re- (шийрэх- шигдэн зууралдах) si-ge-g (шигэг- малын сүүлд наалдсан баас), si-gē-re-(шээрэх- шээс савируулах), si-gē-sū-n (шингэн ялгадас), si-gē- (шингэн мөр үзэх), si-gē- re-ng (шээмтгий), si-ge-He-ī (чигчий (жигжиг) хуруу), si-gī-re (амьтны нарийн шилбэ, таахай) cf. si-γā-ra (шаар- шийр), si-γā-ra- (шаарах- гэдсэн дэх хүүхэд доошлох, шингэнээс өтгөн нь тунах), si-gū-, sū-gū- (юмнаас тухайн юмыг ялгах, шингэнээс өтгөнийг , өтгөнөөс шингэнийг ялгах), si-gū-le-ng (алба гувчуур хүү сан хариуцагч), si-gū-m-Ni (алив юмыг шүүн үнэлэх нь), si-gū-sū (юмын шингэн зүйл, идээний хувь), si\ ū-gū-r (шүүрэн шанага, үсний сам), si-gū-re- (юмыг цочмог барьж авах), sū-gū-re- (шингэн нэвчих) si-(gū)-r-ke-ī (түүхий мах, дутуу дулимаг), si-gū-de-rī (ногоон дахь жигжиг усан дусал) зэрэг үгс нь нэг гаралтай юм. Учир нь, шингэн зүйл алив юмнаа нэвчин нэвтэрч “шигэх” чанартайд оршино. Үүнтэй холбогдуулан, “γa” хэмээх үе-утгалбарыг үзнэ үү¹⁰

6. še-ū (хужир шүү, арьсыг идээлэх идээ), se-ū-le- (арьс идээлэх) Энэхүү “si-γa...” гэсэн хоршмол үе-утгалбар нь хурц үзүүр бүхий зүйл өөр биетэд шивж орох, шулуун шууд чиглэх гэсэн утгатай бөгөөд энэ хоршсон үе- утгалбарын завсар “-ng” авиа-утгалбар шурган орж, ус зэрэг зүйл юманд нэвчин нэвтрэх чадвар бүхий юмыг нэрлэх үг үүсчээ. Үүнд: si-(ng) ge- (шингэх), si-(ng)-ge-n (шингэн) нь si-ge- (шигэх), si-be- (шивэх), si-ba-(шавах), si- γā- (шаах) зэргээс үүсэлтэй нь тодорхой бөгөөд “-ng” авиа-утгалбар нь “үргэлжид жигд хөдлөх” утгыг нэмж байна.

1. “ba-si-, si- ba-“ гэсэн тонгорлын “ba...” нь “ma” үе-утгалбартай сэлгэж, ma-si (хир хэм их), ma-si-la- (алив юмыг бүрэн шийдэх, гүйцэтгэх), ma-si-γū (гэдэс дотор их идсэнээс бөөгнөрч аягүйцэх) (Жич, энэ өвчнийг төвдөөр “ma zhu” гэдэг ажээ) ma-si-γa-da-, ma-si-γū-ra-, ma-si-γū-tu- (машуутах) зэрэг үгс үүссэн ба “бөөгнөрч бөглөрөх” гэсэн

⁹ Ш.Цэцэнцогт . Монгол үгсийн язгуурын толь. Жанг Жияа Кеү, 1988, 989-р т.

¹⁰ М.Базаргагчаа. Утгын чуулган. Уб., 2002, 208-212-р т.

утгатай ажээ. Энэ үг нь “ma~ba”-гийн сэлгэцээр үүссэн тул ba-si-yī- (овоорох), ma-si-yī- (томрох, бөөгнөрөх) гэсэн дүрслэх үгээс эхтэй юм.

2. mu-si-yī- (зөрүүд байдалтай байх, үл мэдэг инээвхлэх, муруйх), mu-si-ya-г

3. mi-si-yē-(өчүүхэн инээмсэглэх, инээхийн хүндэтгэл үг), mi-si-ge-l-He (инээмсэглэх)

4. mo-si-yē- (инээхийн хүндэтгэл үг), mō-si-yē-l-te, mi-si-ye-l-te (тавтай инээмсэглэх нь) Энэхүү “ma...” толгойт үг нь мөн л “овоорох бөөгнөрөх” гэсэн утгатай юм. Өчүүхэн инээмсэглэхэд уруул бага зэрэг овойх байдалтай болдгийг бид мэднэ. “si-ba-” гэдгийн “ba” нь “ma”-гаар сэлгэвэл


1. si-m-da- (түргэлэх, мэрийлт гаргах, шаардах шахах), m~ba, si-b\`a-da- (байн байн шаардах) si-b\`a-da-γū (түргэн, шахам, шаардлагатай), si-m-da-γā-i (ховдог сувдаг, гавшгай шаламгай), si-m-da-γū (яаруу шамдгай), si-m-da-γū-la- (яаруулах), si-m-da-γā-yi-la-(ховдоглож сувдаглах), si-m-da-γā-yi-га-, si-m-da-γā-yi-tu-(ховдог зан гаргах), simdayūn-(шуурхай түргэн), si-ma-la- (юмын зах хөвөөг эргүүлж “овоолох”, simara- (зах сэжүүрийг эргүүлж “овгор бөөн, цомхон болгох”), simarga (шууран орох цас), simarga (нойтон цас бөөн бөөнөөр хаялах) cf. ša-m-bā-yi- (овоорох), si-ma-γū-l (эрэгчин нь ургамлын шүүс, эмэгчин нь амьтны цус сорогч нисдэг ялаа)

2. šumā\`ū- yi- (шумайх- хатсанаас хомойх)

3. šo-m-bū-yi-(шомбойх- өчүүхэн шовгор болох)

4. si-me- (сорох, хөхөх) si-me-l-deg хайлсан өөхнөөс үлдсэн шаар), si-me (шүлт шүүс) si-me-de- (мэрийх, чармайх), si-me-d-ge-l (орлогын хувь татвар), si-me-tū (мэрийх чармайх, хүсэж дурлах). “-be~me” гэж сэлгэсний “-be”-т үг нь гаднаас дотогш орох утгатай бол “-me”-т үг нь дотроос гадагш сорох утгатай юм. Ингэж эсрэг утгатай боловч “si-me-tū-” (мэрийх дурлах), si-me-d- (шингэх нэвтрэх) “уг юманд ихэд дурлах, эрс чиглэх” гэсэн “be”-гийн утга хадгалагдаж байна. Si-m-kū- (шимхэх- ялаа шумуул юмны ан завсарт шургаж орох)

Ийнхүү хоршмол үе- утгалбар нь



гэж харилцан эсрэгцсэн холбоотой сэлгэж “овоорох бөөгнөрөх” гэсэн утга бүхий дээрх үүр үгс үүссэн нь нэлээд эмх цэгцтэй тогтолцоотой байна.

Мөн “si” үе- утгалбарын эгшиг нь гээгдэж, уг үе- утгалбар задарч, “s” гийгүүлэгчээр үе- утгалбар төгсгөх болсноос гадна, “si”-гийн эгшиг нь өөр эгшгээр сэлгэн, утга салаалах болжээ. Жишээ нь:

1. `ba-su- (дээрэлхэх доромжлох) гэсэн үг нь “ba-si-”-аас үүсэлтэй юм. Юу гэвэл, өөрөөс бусдыг өчүүхэн гэж ихэрхэн цээжээ өргөн, хамраа сөхөж, “том болох” гэдэг нь “баших, башилдах буюу буур шавах мэт дүр төрхийг үзүүлбэл “ba-su-” гэж утга аандаа бий болдог байна. Үүнчлэн “bo-s-” (хэвтээ суугаа байдлаас хөл дээрээ өндийх) гэдэг нь “s”-ийн арын эгшиг гээгдсэн болохоос, ba-su- (басах)-ын дээшлэх утгатай төстэй байгааг анзаарч болно. Bo-su-ya (үүдний доод хөндлөн, усан доторх нуугдмал хад) нь “bo-s-”-тай холбогдох ба дээр дурдсан bo-šū-γ (bo-si-γ) (ивээл хайр, иш үндэс зарлиг

зөвшөөрөл)-ийн “овоорох бөөгнөрөх→ихийн ашиг тус их байх” гэсэн утгатай алсуураа сүлбээтэй шиг санагдана. Үүнд: asiγ, e-si, kesig, bisalya-, asi-tā-i, a-si-ūgēi” зэрэг үгийг харьцуулан үзнэ үү. Мөн “šobqu, šobūyi-” зэрэг үгтэй дүйлгэвэл “уг юмаас иш ургах, гадагшлах” гэсэн утга тодорно.

2. “bosuγa (bošuγa)” гэгч нь үүдний доод хөндлөвчөөс гадна шадар залгаа (босго өртөө) усан доторх бартаа, сумын албан ажилд зарагдагч бага тушаалтан) зэрэг утгатай нь “во-si-γ”-ийн ерөнхий утгатай таарч байна. Толь бичигт “bosuγa, bošuγa” (тамга сумын алба хөөн нийлүүлэгч, шаардаж шахаж алба нийлүүлэгч), “bosiγ” гурвыг өөр өөр үг гэж үзсэн боловч “бөөгнөрөх, овоорох” гэсэн анхдагч нэг утгатай байна.

3. bu-s-qa- (хальскийх, натхах, үргэх, зайлах, булгах) нь гэнэт нэг тийш “овойх” бултайх (булгах) гэсэн утгаараа “basu-, bo-s-”-тай гарал нэг байж болно. “bu-” үе-утгалбар нь “mu” үе- утгалбартай сэлгэвэл mu-s-ki-(мушгих), mō-s-ki- (мөшгөх) хэмээх үг үүснэ. Энэхүү “зайлах булгах” гэсэн утга бүхий “busqa-” гэсэн үгээс “bu-sa-ni-” (бусних, бултаж зайлах), bu-sa-γ (хэсэг), sa~ta: bu-ta (бут үсрэх) зэрэг үгс үүссэн нь “овоорч бөөгнөрсөн юм нь огцом хугацаанд гэнэт хөдөлснөөс сарних бусних” утга бий болсон нь нэлээд өвөрмөц юм.

4. “busani-, busay” гэдгийн дэд үе- утгалбарын “a” нь “i, u”-тай сэлгэж, “busu, bisi, busud, bisid, bisire-(būsire-) busi, (būsi), busur” зэрэг үг бүтсэн нь уг юм сарниж бутарснаас хэсэг бусаг хэмээх үг үүсгэж, улмаар уг овоорч бөөгнөрсөн юм маань өөр юм болсныг заах утга салаалжээ.

5. bō- sū- (бөглөх, хаах), vō/ ū-s-ke- (бөсгөх- айраг зэргийг хөөсөртөл бүлэх) гэдэг нь нэг талдаа “хаах, бүчих”, нөгөө талдаа “эсэх, эсгэх” утга агуулах ажээ. Өөрөөр хэлбэл, тухайн зүйлийг эсгэхийн тул хааж хучих болдгоос үүдэлтэй юм. Иймд эхний “b” гийгүүлэгч гээгдэн, уг үе- утгалбар задгайрч ǒ-s- (өсөх), e/ i-s- (исэх), e/ i-s-ge- (исгэх), e-s-kū-le-ng (эсгэлэн), ū/ e- sū-g (исэг) зэрэг үг бүтжээ.

“bi~bu~bū- si” зэргийн эхний үе- утгалбарыг үгүйсгэх утгатай “bū- túgei, bi- tegei (битгий)-тэй адил гэж үздэг нь дээр өгүүлсэн “салах сарних” буюу уул юм эс орших утгаас үүдэлтэй биз ээ. Энэ “busu, bisi, būsi, busi” зэргийн эгшиг нь “a”-гаар сэлгэж, “өөр, ондоо, нөгөө, ахин дахин, эс тоох” гэсэн утга бүхий “ba- sa” (бас л, бас ч) хэмээх ганцажсан холбоос бүтээвэр бий болжээ¹¹

1. Эдгээр “s”-ээр дэвсгэрлэсэн үгс нь ba-si-, ba-si-γū, bu-si-γū (бушуу) зэрэг “овоорох, бөөгнөрөх” гэсэн үгээс үүссэн ба “γa-si-l-, γo-si-γū- (гошийх) зэргийн “si”-гээс “s” дэвсгэр үүсэж, “ba” үе- утгалбар нь “γa”-тай сэлгэвэл “γa-sa-l- (өвчин зовлон тохиолдож, энэлэн шаналах) хэмээх үг үүсэх ба улмаар “онцгой сэргэлэн” хүүхдийг γa-sa-n\ g (гасан) гэдэг нь “γa” нь “онцгойлон ялгарах”, “sa” нь “салах сарних, задгайрах” гэсэн утгатай ба “-n\ g” нь “тасралтгүй үргэлжлэх” гэсэн утгатай ажээ. “γasal-” гэдэг ч ер хэвийн үйлээс онцгой өвөрмөц тохиол энэлэл” гэсэн утгатай ба гагцхүү “тасрах, ялгарах” гэсэн сөрөг утгатай ажээ. (Эмх цэгцгүйг “isiγ bisiy” гэнэ)

2. γo-sū-γi- (госойх- бүдүүрэх, таргалах, томрох) нь “γo-si-γū”-оос салаалжээ.

3. γu-sū-γi- (гусайх- урт нарийн болж, нягт чивх болох) нь “γu-si-γū”-аас үүсжээ.

4. ge-si-gū (гишүү), ge-si-gū-n (гишүүн), gi-si-gū-ne (гишүүнэ) зэргийн “si” нь “i”-гээ гээснээс “gi-s-gi-, gi-s-ki-” (хөл шигэх→алхах) хэмээх үг үүсжээ. Үүний “ki~gi” үе- утгалбар нь “ki-” (хийх үйлдэх, багтаах) гэсэн тусах үйл үгээс эхтэй бөгөөд “ki” нь “kū”-тэй сэлгэж, эхний “g” нь гээгдэн, i-s-kū-l- (өшиглөх- хөлөөр дэлдэх) хэмээх үг

¹¹ М. Базаррагчаа. Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай, Уб., 2003, 100-р т.

бүтжээ. “qa-si-”-ын “si” нь дан “s” болох нь буй. Монгол бичигт гурван муж захирах ноёны “qa-s-qa” (хасах) цол байдаг нь qa-ša-γā (хашга)-аас үүсэлтэй аж¹² qa-s-qa- (биеэ хашиж өмөглөх хэцүү байдал: хасхаг хүн, хасхаг морь) гэдэг ч “qa-si-” (алба хаших)-аас бий болжээ. Төмрийг монголчууд “qasi” (хас) (дагуурт “kasō” гэдэг аж) гэдэг нь “хашиж нягт болох, хатуурах” гэсэн утгатай байж болох учир “хас төр” гэхчлэн хэлэлцдэг байна. Мөн тулганы босоо төмрийг тойруулан хашиж бэхэлсэн цагариг төмрийг “qa-sa-γ” (хасаг- тулгын цагариг) гэнэ.

Энэчлэн qa-s (нягт бэх бат чулуу) (qa-s tamaγa), qo-si (холболдох, нягтран нийлэх) qu-su-n (нягт бэх мод), qu-si (тураг мод, мөнх ногоон нарс мод, үрээр тос шахдаг) зэрэг үгс ч “qa-si-” (хаших), si-qa- (шахах)-аас ч үүсэлтэй байж мэднэ. Мөн qa-sa (хас гуя, гуя хас- бүдүүн гуяны дотор тал) ч “хаах хаших хавчих”, qa-s (хас- дөрвөн үзүүрий нь тэгш өнцгөөр нугалсан тоонолж хэлбэртэй дүрс) зэрэг үгс нь дотогшоо нягтрах буюу төвд тэмүүлэх чигтэй бол qa-sa-γ (хасар- том, томрох, сүрлэг) qa-sa-γ (хасаг үндэстний нэр, “r, γ” сэлгэх тул энэ нь “qa-sa-r”-аас үүсэлтэй юм) гэвэл гадагш тэлэх буюу төвөөс зугтах чигтэй утгыг заажээ. Тухайлбал, “si” буюу “i”-т үгс нь дотогш чигтэй тул “бат бэх нягт” утгыг зааж, “sa” буюу “i”-гүй үгс нь гадагш чигтэй тул сүрлэг овортойг заасан шиг аж. Жишээ нь:

qasir basir – qasar, basar, asar (асар басар нохой)

asir (маш)- asuru (асар том) (Энэ хоёр үгийн эхний сэлгэмэл “b~q” гийгүүлэгч гээгджээ)

qo- si – qo-s (qo-u-s) (“qosi” гэвэл хоёр юм нийлснийг “qo-s” гэвэл хоёр юм саланги зэрэгцэж байхыг тус тус заана)

ke-si-g – ke-se-g

kō-si-ge – kō-s-kū-le- (мах хөшиглөх)

kō-si-g (онгоц салны ялуу (хэрээс) мод) – kō-s-ke (хөсөг уналга, kōdel-; s~d\e)

Эдгээр хоршмол үе- утгалбарын эхний гийгүүлэгч нь гээгдэн үе- утгалбар задгайрч шинэ үг бүтээх арга бий. Үүнийг алтайн хэлшинжлэлд үгийн эхний “p”-гийн хууль гэдэг боловч бид үүнийг “үе- утгалбар задгайрах ёс” гэдэг билээ. Үүнд:

1. qa-si- (хаших), ba-si- (баших), ba-si-yī (башийх)-ын “b” гээгдэж, үе- утгалбар задгайрч, a-si-γ (бөөн олз, модонд гарах булчуу, сүйх унжлага), a-su-ru (том), a-su (том их), a-si-r (асар), a-si-da (өнөд үүрд) (бөөгнөрч тогтвортой орших) ā-šā-r (аашаар-алгуур, аажим, хожид), башиж бөөгнөрсөн юм бат оршиж, өнө удаан байх, хожим, хожид болтол байх үе хугацаа), a-si (тав тух), a-si-la- (тавтай амрах) зэрэг үг үүссэн нь “бөөгнөрснөөс тавтай орших, бөөн олз олох” гэсэн утгатай үг болжээ. Эдгээр нь бас “ma-si” (маш) хэмээх үгээс салаалсан юм. Г.И.Рамстедт “Халимаг герман толь”-доо asṙ kün (аварга хүн) aš (asi, asida) (ашиг), asiγ (ашиг) man, aisi, uig. asuq. čag. asiq; ašlū (asilaγū - тэвш), ašu (asiγū) (өшөө) kir. ašū< асуу (уур хилэн) cf. асуу (хүч, хөлс, ач хариу)¹³ зэрэг жишээ татсан нь “qasi-, basi-, masi” зэргээс гаралтай юм. Kōsiyē (хөшөө)-ээс “k” гээгдэн “ōsiyē (өшөө, өс, өш) хэмээх үг үүсчээ.

2. i-si-ge-ī (үс ноосыг ширэлдүүлэн дагтаршуулж хийсэн эдлэл), (si-se-ge-ī) гэж эхэндээ “s”-тэй хувилбар байдаг нь “s~k”-гийн сэлгэцтэй холбогдож мэднэ. e/ i- si-ge (ямааны нэг жил болоогүй төл) хэмээх үг ч эсгий буюу үс ноосоор нь, тухайлбал, ямааны төл (ямааны үр удам, иш үндэс), эсвэл, үсний нь зөөлөн нявталхнаар нь

¹² Ш. Цэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Жанг Жияа Кед, 1988, 943-р т.

¹³ G.J. Ramstedt. Kalmückisches wörterbuch. Helsinki, 1935, p. 17

нэрлэсэн байж болох юм. Эсгийг хийхдээ ноосыг хэсэг хэсгээр нь зулж, бөөгнүүлэн ширэлдүүлж хийх тул “isegei” хэмээх үг нь “ba-si-, qa-si-, ke-si-g (a-si-γ)” зэргийн хоршмол үе- утгалбарын эхний гийгүүлэгч гээгдсэнээс үүссэн бөгөөд хөө торггийг “isū” (утаа тортог) гэх нь “бөөгнөрөх, овоорох” гэсэн утгатай. “qasi-, basi, bi-si- (bisilay, basilay) зэргээс үүсэлтэй болов уу. Энэ үгийг уйгар, түрэг, манж хэлэнд “isu, is” гэдэг ажээ. Үүнийг Г.И.Рамстедт “išu, isu” (давирхай), alt, šor, uš (утаа), uriyangqai. Yš (утаа тортог), tung. ihua (утаа) (р. 211) гэж харьцуулсан байна. Энэ нь дээр өгүүлсэнчлэн монгол хэлний bi-si-la-γ, ba-si-la-γ (сүү эздүүлэн башиж шахаж хийсэн нэгэн зүйл цагаан идээ), bi-si-la- (нягтлах, “ээдэж бөөгнөрөн, шингэнээс (шар сүүнээс) ялгарах), bi-si-l-γа- (боловсруулах, нягтлан бодох, гүн сэтгэх) зэрэг үгийн “в” нь гээгдсэнээс “i-sū, isi” (ис тортог) хэмээх үг салаалжээ. Утаа тортог бөөгнөрснийг нь “ис” гэх ажээ.

3. ge-si-gū-n (гишүүн), ge-si-gū (гишүүн) гэдэг үгийн тэргүүн ба дэд үе- утгалбарыг байр сэлгэн тонгорговол si-ge- (шигэх), si-be- (шивэх), si-ba- (шавах), si-γā- (шаах) зэрэг үгс үүсэх ба “basi-, qasi-” зэрэг нь бөөгнөрч, уг юмын орших иш үндэс болох зэргийн утгаас “e-si” ургамлын гол бие, багаж зэвсгийн бариул, үйл явдлын шалтгаан үндэс, уг сурвалж, эх үндэс (man. xesin, uig. tūr, is) хэмээх үг салаалан, esi qatun, esi eke, esi qadam (iš xadm (р. 211) гэж хэлэлцэх болсон байна. bosiy (бошиг- эш үндэс), bosuγa (саад хөндлөн, алба хөөн нийлүүлэгч) хэмээх үгтэй харьцуулна уу. Ийнхүү шигж шавж бөөгнөрснөөс ургаж гарсан хэсгийг “gesigū” буюу “esi” гэх үгээр илтгэх болжээ. Өөрөөр хэлбэл, ke-si-g (бөөн баан олз) гэсний эхний “k” нь гээгдсэнээс “esi” (үндэс язгуур) хэмээх үг бүтсэн ба нөгөө талаар e-si-ge, i-si-ge” (ишиг) хэмээх үг ч “ямааны иш язгуур болох төл”-ийг “eḷi-si-ge” гэж нэрлэсэн байж болно. Ер, алив юм бөөгнөрөн цогцлох нь юм үүсэн гарах, үндэс суурь бий болох нь дамжиггүй болно. “esile-” гэвэл “уллах суурилах” гэсэн утгатай ажээ.

Г.И. Рамстедт дээрх бүтээлдээ gi-s-ki\ gi- (гишгэх- алхах), i-s-ke-, gi-s-ki-, i-s-ke-ldū-gū -г (морины өшгөлдүүр) (р. 211) гэж тэмдэглэсэн нь “ge-si-gū-n”-ээс эхтэй болохыг дээр дурдсан билээ. “gi-s-ki-, i-s-kū-l- (өшиглөх) ḡ-s-ki-le- нь үе- утгалбар тонгорсноос “si-ge-, si-γā” гэсэн үгтэй холбоотой болно. Үүнээс “азарга гишгэх” гэдэг хэлц үг бий болсон байна. ḡ-sū-ge-ḡ (өсгий) хэмээх үгийн “ḡ-sū-” нь “gi-s-ge-” гэдгийн эхний хоёр үе- утгалбараас улбаатай байж мэднэ.

4. kḡ- si- (хөших хөндөлдөх) хэмээх үгийн эхний “k” гийгүүлэгч гээгдэн, үе- утгалбар задгайрнаас ḡ-si- (өших) (V), ḡ-si (өш хонзон) (N) ḡ-s (өс), ḡ-si-yē (өшөө) хэмээх үг салаалдаг нь “хөндөлдөн хөшиж, саад болох” гэсэн утгаас бий болжээ.

5. Г.И. Рамстедт оу (o-si (?), oštē bolxa (juntē bolxa) (р. 291) гэсэн жишээ татсаныг үзвэл, энэ нь “qoγula qosi” (хоол хош) гэдгийн “q” гийгүүлэгч гээгдсэнээс “o-si” (юм) гэж үүссэн байж болно.

Дээрх сэлгэвэр салаалбарын зэрэгцээ “si” үе- утгалбар нь “ḡi” болох нь тохиолдоно. Учир нь, шүргэх “si” нь хамжин шүргэх “ḡi” болдог нь “ḡi” үе- утгалбарын дотор “si” багтаж байдагт оршино¹⁴ Хамжин шүргэх “ḡ, H” нь “s, si” төдийгүй, хамжин “t, ti” гийгүүлэгчтэй хослон бүтдэг нь “s, t” (d)-гийн сэлгэцээс эхтэй болно. Иймд ba-si-г (башир)-аас ba-ḡi (арга башир, заль мэх), qa-si-г (хашир, бөх бат)-аас qa-ḡi- (хавчих, гацах) (γaḡi - (гачих), γaḡa- (боох гачих), γa-ḡa-γā (уул усны бэрх газар), γa-ḡi-γ (ховор хомс), qa-sa-г (хасар басар)-аас qa-ḡig (тас бүргэд...том бүргэд), qa-ḡa-г (нүүр болоод

¹⁴ М.Базаррагчаа. Монгол хэлэнд хамжин шүргэх гийгүүлэгч хэрхэн үүссэн бэ? МУИС. МСС., ЭШБ. XVI боть, Уб., 2000, 51-71-р т.


юмын хоёр талын халхавч маягтай хавтгай) гэж үүссэн байж болох юм. Мөн “qa-ša-ng” (олон чанасан тос, хойрго)-аас qa-ši-n (сонин этгээд), qa-ši-g (нэмж чимэх) гэж үүссэн нь “ya-si-γū-n, γu-si-γū-n, γa-si-l”-аас эхтэй юм. Хашин тос нь үнэндээ гашилсантай адил тул “qa-si-, qa-ši-” гэсэн хоршмол үе- утгалбар нь “гойд, гоц амттай” гэсэн утгыг далд тээж явдаг байна. qa-si (сул дагалдах явах хөтөч хүн, юмны зах хөвөөний дотуур тойрон даруулж оёсон нарийн мөшгөөр, хош хударга, хоол хош), qo-šu-ng (алиа)-аас “š” нь “с” болон сэлгэж, “бусдыг шоолон өгсөн хоёрдогч нэр” гэсэн утгатай “qo-ši” хэмээх үг салаалжээ. Мөн “qa-ši, qo-ši” гэж хоршин хэлдэг нь мөнөөх “qa-ša-ng” хэмээхээс үүсэлтэй ба “qa-ši-n, qa-ši-g” хэмээх үгс ч гарлаараа холбогдоно. “qašang” нь олон чанаснаас амт нь гажиж, гашуурах нь “qoši, qaciṅ, qaciṅ” зэрэг салаалах үүсвэр болжээ.

“kō-si-, qa-si-, ō-si-” хэмээх үйл үгс “саад хийх, хаалт болох” гэсэн утгаас “ō-ši-” (өчих- хариу үг хэлэх, асуусан амыг хаах, өчих мэх- хариу мэх) хэмээх үг бүтжээ. Үүнчлэн “хатуу хучилгатай, жимсний үр, эрийн өндөгний уут” гэсэн утгатай “qu-si-γa” хэмээх үгийн “si-” үе- утгалбар нь “ši-”-тэй сэлгэж, “хаах, халхлах” утгатай “qu-ši-” хэмээх үйл үг салаалсан байж болмоор.

basi- (баших)-аас baši-γū (бачуу), ašiγū bašiγū (ачуу бачуу- яаруу давчуу) хэмээх үг, “basi-, qasi-” зэргийн сэлгэмэл “b~q” гээгдэн, asi (аш- ая тун), a-si-γ (ашиг тус, орлого) хэмээх үг үүссэнээс “-si” нь “ši-”-тэй сэлгэснээр “a-ši” (бусдын олгох тус хайр, үр дүн, хариу талархал, ацаг хөлс; хариу өшөө) (uig, tur, aedzir) хэмээх үг салаалжээ. Өөрөөр хэлбэл, “a-si, a-ši” хоёр нь нэг гаралтай үг юм. Мөн a-ši-γ (хүч хөлс) гэсэн үг нь “asiγ”-тай гарал нэг ба үүний дэд үе- утгалбар болох “-ši” нь “ša” болон сэлгэж, a-ši~ a-ša (алц салаа, ац мод, гохдох мод, өөш уядаг хэлтэй мод) хэмээх үгс бий болсон нь e-si (иш) хэмээхээс эхтэй юм. Тухайн нэг бөөгнөрсөн юмнаас (бөөгнөрч боловсорсноос) өөр юм “тасран ургаж” гарахыг kesig (хишиг)-ээс “k” нь гээгдэн “esi, asi, asiγ” зэрэг үг үүссэн нь “ašiγ, aši, aša” (салаа мөчир ацлах, бөөгнөрснөөс ашиг ацаг “ургах”) хэмээх үг салаалсан байж болно. Мөн “basi-, basu-, qa-si-, asi, asiγ” зэргийн “si” нь эгшгээ гээвэл asqa- (асгах- бялхах цалгих, үйрэх бутрах), asqara- (асгарах), asara- (асрах- арчлах, энэрэх хамаарах), asa- (асах- авирах, ноцох, халгих) зэрэг үг салаалсан нь “бөөгнөрсөн юм задрах, эсвэл, томрох бөөгнөрөхөөс өгсөх, хамаарах халдах” гэсэн утгатай юм. Цаашилбал, “basu-, bas-” зэргээс “asa” (ас- эгц босоо, цэх шулуун) asa- (асуух), asaγū-, asaγ- (асуух) хэмээх үг бүтжээ. Үүнд: “asara-” гэгч нь хүн амьтныг бөөцийлөн хашиж хаацайлан “тордох” гэсэн утгатай нь “qasi-” (хаших хаах, хамгаалах)-аас үүсэлтэй аж. “asa-, asaγ-, asaγū-” (асуух) гэх нэг үгийн хувилбар нь “kesig”-ээс “esi”, “qasiγ”-аас asi, asiγ, “kōsi”-өөс “ōsi-, ōs-” (өших, өсөх), “bōs”-өөс “ō-s-” (өсөх) хэмээх үгс үүссэн шиг “basi-, qasi-”-аас “asaγū-” асуух- хурснаас (юм мэддэгээс) юм үүсэх, эсвэл юм мэдэх) хэмээх үг салаалжээ. Иймд гал ас- (asa-), юм асах (асуух) гэсэн эс тусах ба тусах үйл үгээр ялгарсан ижил нэр (омономия) нь гарал нэгтэй болно. Харин “орой хөнгөлсөн мал, хөнгөлөхөд тал бөөр буюу судал нь хоцорсон мал, уулаасаа дотроо имтэй бөгөөд хөнгөлж болохгүй мал, эрдэм мэдлэггүй хүн”¹⁵ гэдгийг “a-s” гэж үе- утгалбар задгайрч, задарсан хоршмол бүтээвэр нь “ba- si-” (баших- алив юмсын дотор нэг юм хуралдах), qa-si- (хаших- юмсыг бөөгнүүлэх, хураах) гэсэн хоршмол үе- утгалбарын сэлгэмэл “b~q” нь гээгдэж “i” эгшиг нь “a”-тай сэлгэснээс үүссэн байна. Эдгээр утга нь имээ хадгалах асман гэдэгтэй адил байна.

¹⁵ Ш.Цэцэнцогт. Монгол үсгийн язгуурын толь, Жанг Жияя Кеү, 1988, 116-р т.

qusiya (хушга- модонд ургадаг жимс, хальс хатуу, эрийн өндөг, бэлгийн булчирхай, түүний уут) (tur, koz, sanskr, vasika) хэмээх үг нь qa-si-ya (хашаа), qa-si- (хаших) ba-si- (баших), basiya (башга цэцэг) зэргээс эгшгийн сэлгээгээр салаалсан ба хушга нь 1. Дотроо цөмтэй, 2. Гаднаа хатуу хальстай зүйл тул “basi-, qasi-”-тай утга нэг ба qu-si (хуш- тураг мод, зууван үрээр нь тос шахаж болно), qu-si-ya (хушга)-ын “-si-” үе- утгалбар нь “-či” үе- утгалбартай сэлгэж, “нэг юмыг юмаар нөмрөх битүүлэх, халхлах” гэсэн утгатай “qu- či-” хэмээх үг салаалсан байж болох юм.¹⁶



¹⁶ М. Базаррагчаа. Монгол хэлний “qasi-, basi-, masi, asi, esi, ösi-, isi-” зэрэг хоршмол үе- утгалбараас үүссэн үг. МУИС., МХСС. Монгол судлал, 19-р боть, Уб., 2008

гэж харьцуулбал, “b~qa...-si” гэсэн хоршсон үе- утгалбар нь “бөөгнөрөх, нягтрах, бөөн нягт, хаах халхлах, бөөгнөрөхөөс тасрах ангижрах” (busu, bisi) гэх утгатай бол “b~qa...-s\а...” гэсэн хоршмол үе- утгалбар нь “томрох бөөгнөрснөөс задрах салах буюу исэх, түүнээс өөр юм ба үйл бүтэх” гэсэн утгатай болно. Энэ нь “si” нь “бүтэх” (sige-, sibe-), “s\а...” нь “эвдрэх” (sal-, sula) утгатай холбоотой ажээ. Хэрэв “qa~ba...” үе- утгалбар нь “ялгарах, гоц, ганцжих” утга бүхий “-ya...” үе-утгалбартай сэлгэвэл

1. ya-si-	yasil-, yasiyūn, yasiyān	2. yasal-	3. yasang (эвгүй үнэр, гажиг)
	cf. si-γā- (шаах)		cf. sa(γ)-ya- (сагах)
γo-si-	γosiyū- (гошийх)		γosūyi- (госойх)
	cf. siγō (šou) (ад шоо үзэх)		cf. so-yū-yi- (согойх), soyū (согоо)
γu-si-	γusiyū- (гушийх)		γusa/ uyī- (гусайх), γušuyūn (γasang)
	cf. si-γū-d (шууд)		cf. sa-γū- (суух)
ge-si-	gesigū, gesigūn, e-si, si-ge-		ges- (гэсэх), e-s- (i-s-) (исэх)
	gesigūne cf. si-ge-		se-ge- (сэгэх- шогших хатирахын хооронд явах)
gi-si-	gisi (гиш өвс)		gisgi- (гишгэх)
	cf. si-gi-d- (шигдэх)		cf. si-ge-, si-gi-d- (гишгэх, шигдэх)
gō-si-			
gū-si-			

gesigū (гишүү)- гэдгийн “эхний үе- утгалбар “g” гийгүүлэгчээ гээн, үе- утгалбар задгайрч¹⁷ e-si (иш) esilegūn (ишлүүн- дедукция), “si-” гэсэн дэд үе- утгалбарын “i” эгшиг гээгдэн, үе- утгалбар задарснаас gi-s-gi-, gi-s-ge- (гишгэх- 1. Алхах, 2. Азарга гишгэх), i-s-gi- (гишгэх) гэх зэрэг үгс үүсчээ. Гэтэл энэ нь “ge-si-” гэсэн хоршмол үе- утгалбар байр сэлгэсэн, si-ge- (шигэх), si-γā- (шаах), sa-γū- (доош суух) хэмээх үг бүтэж, улмаар “эх амьтан буюу өлөгчин нохой (жингэр) гэсэн утгатай “gicīi” (гичий) хэмээх үг нь “ge-si-” гэсэн үгийн “si” нь “ci”-гээр сэлгэж үүссэн байж болох юм. Харин Ш. Цэцэнцогт “gicīi”-г gicig, (gölüge, gölöügei)-тэй гарал нэг бололтой¹⁸ гэж үзжээ.

Мөн si-ba- (шавах), šo-bu-yi- (шовойх), sibūge (шөвөг), šöbüyī (шөвийх), sibe- (шивэх), sibege (шивээ хиагт) зэргийн дэд үе- утгалбар “ba...” нь “ma...” –тай сэлгэж, улмаар “s” нь гээгдэн, үе- утгалбар задарвал “ibaγana-” (явганах) ibegene- (ивэгнэх) зэргээс ibe- (ивэх- хавчуулах, налах шахах)<sibe-, siba-“ ibegē- (ивээх- тэтгэх, уг юмнаа юм нэмж өгөх) kir. zewa- (ивээх)¹⁹ ibai (явай- юмсын гадаад дүрс) хэмээх үгс үүсэж, “ba” нь “ma”-гаар сэлгэж, imayta (ямагт- үргэлж, хэзээд) imay (ямаг- хэзээд, ep) гэсэн үг нь simda- (шамдах- үйл явдал дараа дараагаар ойр ойрхон үргэлжлэх), simda- (шамдах- шаардах), simala- (шамлах- ханцуй зэргийг хойш “эвхэн овоолох”) хэмээх үгээс үүсчээ. Иймд “imay, imayta” хэмээх үгнээ “байнга үргэлжлэх” гэсэн цагийн утга үүсчээ. Энэчлэн sime- (шимэх- удаанаар алгуур сорох), simaga- (шамрах), simaγa (шамарга), simeldeg (шимэлдэг) зэрэг үгс нь “ibaγana-, obuγana-, abaγana-” гэсэн дүрслэх үгээс үүсчээ.

Үгийн эхний сэлгэмэл “q~b” гийгүүлэгч гээгдсэнээс a-sa- (асах, авирах), ǒ-s- (өсөх өндийх), ū-sū-n (үс), e-si (иш үндэс), o-s- (осох осгох), i\ e-s- (исэх), i-su (ис тортог), e\ i-

¹⁷ М. Базаррагчаа. Эртний монгол хэлний үгийн бүтэц, түүний зарим онцлог, Уб., 2005, 158-197-р т.

¹⁸ Ш. Цэцэн цогт. Монгол үгсийн язгуурын толь. Жинг Жияа Кеү, 1988, 1270-1308-р т.

¹⁹ G.J. Ramstedt. Kalmückisches wörterbuch. Helsinki, 1935, p. 212 a

súg (айраг), i-s-ge\ i- (гишгэх) зэргийг харьцуулбал “basi-, qasi-, ʧasiyün, gesigün, bos-” зэрэг үгийн “бөөгнөрөх томрох, удсанаас гашлах, исэх, ургах” гэсэн утгаас үүссэн ба түрэг хэлнүүдэд эдгээр үе- утгалбар мөн утгаар хадгалагдсаар байна. Үүнд:

baš- (1. Толгой, бүлэг, орой, эхлэл, төгсгөл, гол, хүний сэтгэл, тарианы түрүү, ургамлын нахиа, өмнө тал, ёзоор) цув. рус. кор. маргi~ мали (толгой), bašak (тарианы түрүү, сумын булцуу, зуурмаг, холион)²⁰, bas- (дарах, шахах, өтгөрөх, гишгэх, нягт бүрэх, дарах, хавсаргах, хурлах, тунах суух) (стр. 74-75), baška (бус, өөр, онцгой, саланги, том) (стр. 92-93), basmak (гутал, баглах, боох, бахилы (бахиал) (стр. 94), beşik (өлгий, балчир хүүхэд, ураг удам, найз, нөхөр, авс) (стр. 123), bešmet (гадуур хувцас) (стр. 123), biš (чанах, болгох, боловсрох) (Н. Поппе монгол хэлний bučal- (буцлах) хэмээх үгтэй холбон үзжээ) (стр. 163), basaya (босго, яс мод, хаалганы хоёр тал, мөргөцөг, шат, дөрөө, авс, дарах барих (баглах), хашаа) (стр. 197), boš (чөлөөтэй, зав чөлөө, салах, нүцгэн) (Н. Поппе осм. Ваša (суллах), mong. bolju- (болзох) гэж харьцуулжээ), bus (хаалт барих, нуух, хаах, сэм чагнах, суух) (стр. 279), biš (айраг бүлэх, холих хутгах, дагтарших) (стр. 309-310);

keš (саадаг- нумын сав, бүс, арьс)²¹ (kir. kesene (бүс) mong. Keseneg (хэснэг- нуруундаа үүрдэг саадаг), kösük (хөшиг, халхлах тор) (стр. 128), kas- (арьс, хальс, холтос, хальслах, холтослох) (стр. 328), kaša (хашаа, гэрийн хана) (стр. 356) гэх мэтээр харьцуулбал, монгол хэлний “basi-, qasi-” гэсэн хоршмол үе- утгалбартай гарал нэг байна. Монгол хэлний үгийн эхний гийгүүлэгч гээгдэн, үе- утгалбар задгайрч, үг бүтэх нь түрэг хэлнээ мөн адил байдаг ажээ. Үүнд: as- (өлгөх, солих, болгон чанах)²², asra- (асрах, өсөх, хамгаалах, хүмүүжих, аврах, оршуулах) (стр. 193), eš (нөхөр, адил, ойр, тулгуур) (стр. 314), i.šik (хаалга, үүд, босго, хаалга хаах эсгий, хашаа, байшин, мал услах онгоц) (стр. 397), is (үнэр, утаа, агаар, алдар, үнэрлэх, анхилах) (стр. 379), osal (залхуу, хэврэг, багасах, муу, чамгүй) (стр. 480), ös- (өсөх, өгсөх, хөвсийх) (стр. 553) гэж харьцуулж болно.

Ийнхүү үгийн эхэнд орсон хоршмол үе- утгалбар нь байр сэлгэн тонгорох учраас эртний монгол хэлнээ үгийн язгуур нь ямагт эхэндээ байх бус, язгуур болсон үе- утгалбар нь дагавар, нөхцөл ч болдог байжээ. Тухайлбал, “va-si-” нь “si-ba-”, “qa-si-” нь “si-qa-” гэж байр сэлгэн тонгорч, ойролцоо утгат үг болон өөр утгат үг бүтээдэг. Иймээс “basi-, siba-” гэхэд аль нэг нь эхэндээ байвал CV гэсэн язгуур болно. Түүнээс гадна хоршмол үе- утгалбар задгайрах ба задрах ёсоор bi-si-la-γ (бяслаг)-аас isüg (исэг айраг), isü (тортог), kös- (хөсөх), bös- (бөсөх)-өөс ös- (өсөх), bosuγa (босго)-оос “bos-” (босох), “basu-”-аас asa-(асах, авирах), asayü- (асуух), “kesig” (хишиг)-ээс “esi” (иш үндэс), “kösi-” (хөших)-өөс ösi- (өших), ös- (өсөх хонзогнох), “basi-”-аас “asi” (аш- тав тохь), vos- (босох), qosiyü (хошуу), qosi, qosilyü (хош, хошлог), “qasi-” зэргээс os- (осох, осгох) гэж үүсчээ. Үүнд: es- (эсэх), esküleng (эсгэлэн), isüg, üsüg (исэг, үсэг) зэрэг нь чийгтэй буюу шингэн зүйл удсанаас эсэж хөөсрөх зэргээр хувирч буй нь “o-s-” (осох- уг юм нягт чигжүү болж, хөлдөн сайртаж, “эвдрэх”-тэй адил “үйл явц” болно. Утгын

²⁰ Э.В. Севортян. Этимологический словарь тюркских языков. Общетюркские и межтюркские основы на букву “Б” М., 1978, стр. 85-88, 89-90

²¹ Л.С. Левитская, А.В. Дыба, В.И. Рассадин. Этимологический словарь тюркских языков. Общетюркские и межтюркские лексические основы на буквы “К”, “К,” М., 1997, стр. 60

²² Э.В. Севортян. Этимологический словарь тюркских языков. Общетюркские и межтюркские основы на гласные. М., 1974, стр. 192

хувьд, уг юмын хаалт болж байсан “b~q” гийгүүлэгч гээгдвэл уг юм задгайрч, өөр төрхтэй болно.

Монгол хэлний qoγūla qosi (хоол хош), qosi qoriyā (хош хороо)²³, qosi (хош- хүрээ, сүрэг, хош дээр хоёр галуу (Гүүний хөх), qosi qoburaγ emegen (хош ховрог эмгэн), qosi qoriyā (багаж)²⁴, qosi- (хоших- хаах, түгжих, цоожлох)²⁵ гэх мэт үгс нь “qasi-” (хаших)~ siqa- (шахах), qosi- (хоших) ~ šoquγūga- (шохоорох), šoquγūrqa- (шохоорхох), šoqu (шох- шог инээдэм), qo/ usiyū (хушуу, хошуу) ~ šiqūui- (шухайх) зэрэг үгтэй гарал нэг байна. Учир нь, “хааж шахах, бөөгнөрөх овоорох” гэсэн утгад нийлж байна. Мөн “Дуугүй бай! Илүү үг бүү ярь!” гэсэн санаатай “qosi” (Хош!) гэсэн бүтэц бус өгүүлбэр байдаг нь “хашиж хаах, хориглох” гэсэн утгаас үүдэлтэй ажээ.

Эдгээр хоршмол язгуур нь якут хэлнээ мөн утгаараа хадгалагдаж буй дараах үгс байна. Үүнд:

- хасы (чанасан будаа)- qasi- (хаших)²⁶, хасāн (өөртөө цуглуулах), хасāl (нөөц), хос (хос хоёр) (стр. 537), ос (хаах, шарх аних), үс (овог төрөл, үр удам), cf. esi (иш үндэс) (стр. 481), асы (исгэлэн, гашуун) cf. γasil- (гашлах), iskūleng исгэлэн (стр. 437), is- (исэх), ācā (өвөг, өвөө) cf. esi. (иш уг) (стр. 446), ōs (хэрүүл, хараал) cf. ōs-, ōsi- (өсөх, өших) (стр. 458), ыс (цацах шүрших) cf. bisi ~ busu (биш, бус) (стр. 465), busani- (бусних);
- бас (толгой) cf. basi- (баших) (стр. 590), басылык (хамгийн хүндтэй, хамгийн чухал) cf. basiyū- (башийх) (стр. 591), бās (нарс, долдугаар сард нарсны зулмыг авч, хатааж нунтаглан гурил болгодог), бāciān (тав, тавуулаа) (Энэ тав гэсэн тоо нь “олон буюу задрах” гэсэн утгаас эхтэй байж мэднэ) cf. basi- (баших), basilaγ (бяслаг) (стр. 594), босхо (чөлөөтэй, сул) cf. bos- (босох), bosiyā (бошго зурам) (өөдлөн томрох) (стр. 595), бысыи (бушуу) cf. busiyū (бушуу), bos- (босох) (стр. 599), бīс (төрөл удам) cf. esi (иш язгуур) (стр. 602), бусар- (чанах болгох, бэлдэх) cf. basi- (баших), bisila- (бяслах), bisilyā- (бясалгах, боловсрох) (стр. 607) cf. busani- (бусних), busu (бус); бус- (чанах, боловсруулах) cf. bučal- (буцлах) (стр. 607);
- мас (мод) cf. masi (маш), (хатуурч нягтрах) (стр. 611), месii (хутгах зуурах) cf. basi- (баших) (стр. 612), мусун (бөөгнөрөх, таарах) cf. basi- (баших), masiyū (машуу) (стр. 615)
- саб (хаах хучих) (стр. 620), сыбах (шаваас) cf. siba- (шавах) (стр. 631), самы (ууц, олон яс нийлэх) cf. siba- (шавах) (стр. 621), самыр (бороо) cf. sibere- (шиврэх), siberi (шивэр- үмхий хөлс), siber (сахлаг ургах) (стр. 621) гэх мэтээр харьцуулбал, “si-ba-, ba-si-, si-ma-, ma-si-, si-qa-, qa-si-” зэрэг монгол үгтэй гарал нэг байна.

²³ G.J. Ramstedt. Kalmückisches wörterbuch. Helsinki, 1935, p. 189

²⁴ Б.Д. Муниев. Кальмыцко- русский словарь, М., 1977, стр. 602

²⁵ К.М. Черемисов. Бурятско- русский словарь, М., 1973, стр. 593

²⁶ О.Н. Бётлингк. О языке якутов, Новосибирск, 1989, стр. 532

РЕЗЮМЕ

В древнемонгольском языке были различные способы словообразования, главным из них является парное употребление силла- семемы, как основной единицы этимологии слов. Путем перестановки силла- семем образуются контактное и дистантное изменения слов. На основе контактного изменения возникают синонимы, а на основе дистантного изменения- другие независимые слова. Напр.

а) basi- (скучиваться, скапливаться) --- siba- (лепить, скапливаться)

qasi- (загораживать, притеснять) --- siqa- (жать, втискивать)

б) qusiγa (грецкий орех, яички, половые железы) --- siqūyi- (быть узким)

kesig (милостыня, благополучие) --- sikūr (зонтик, балдахин)

В результате исчезновения согласных, чередующихся в начале слов появляются новые слова. Это можно назвать законом открытых слогов или открытых силла- семем. Напр. Vasi- (скучиваться), qasi- (притеснять) --- asi (удобство, благоустройство), bisilaγ (сыр) --- isu (гарь), i\ es- (закисать), os- (зябнуть, мёрзнуть), osul (небрежность). С точки зрения изменения значений слов вышперечисленные слова с одной стороны имеют значение “скучиваться” или “возникновение”, с другой стороны --- значение “разрушаться” или исчезновение.

С исчезновением гласных звуков, чередующихся с нулевым во второй силла- семеме возникают новые слова. А это можно назвать законом закрытых слогов или закрытых силла- семем. Напр. bōs- (заквасить), kōs- (возбуждаться) --- ōs- (расти), kōsi- (окостеневать, задвигать) --- ōs- (возненавидеть, затаивать ненависть) – isu (гарь)